

ДУНДГОВЬ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН
ГИШҮҮН ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙ ХӨНГӨН ҮЙЛДВЭРИЙН САЙДТАЙ 2024 ОНД
ХАМТРАН АЖИЛЛАХ ГЭРЭЭНИЙ ЖИЛИЙН ЭЦСИЙН ХЭРЭГЖИЛТЭД ХЯНАЛТ
ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ ХИЙСЭН АЖЛЫН ТАЙЛАН

2024 оны 12 дугаар сарын 20

Мандалговь хот

НЭГ. ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ЗОРИЛГО

Засгийн газрын гишүүн, Хүнс, хөдөө аж ахуй хөнгөн үйлдвэрийн сайд болон Дундговь аймгийн Засаг даргын хооронд Засгийн газрын зарим чиг үүргийг орон нутагт төлөөлөн хэрэгжүүлэх талаар байгуулсан гэрээний хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, үйл ажиллагааны гүйцэтгэлийн үр дүнг хянах, үнэлэх, дүгнэлт зөвлөмж гаргах, үйл ажиллагааны төлөвлөлт, хэрэгжилт, тайлагналтыг сайжруулж, цаашид гарах үр дүн, үр нөлөөг нэмэгдүүлэхэд оршино.

ХОЁР.ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ҮНДЭСЛЭЛ, АРГА ЗҮЙ

Хүнс, хөдөө аж ахуй хөнгөн үйлдвэрийн сайдтай байгуулсан аймгийн Засаг даргын хамтран ажиллах гэрээний 2024 оны жилийн эцсийн хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээг Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолоор баталсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт болон захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”-ын 6.2-т заасан арга зүйгээр Хөгжлийн бодлого, төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтсээс ирүүлсэн тайланд үндэслэн хяналт-шинжилгээ, үнэлгээг хийлээ.

ГУРАВ.ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ҮР ДҮН

Аймгийн Засаг дарга хамтран ажиллах гэрээгээр 39 үүргийг хүлээж, үүргийг орон нутагт хэрэгжүүлэх төлөвлөгөө гарган үр дүнг тооцож ажилласнаар жилийн эцсийн байдлаар төлөвлөгөөний хэрэгжилт 91,5 хувьтай байна.

ҮР ДҮНТЭЙ ХЭРЭГЖСЭН ОНЦЛОХ АЖЛУУД:

“Хоол үйлдвэрлэл, үйлчилгээний газарт тавигдах шаардлага MNS4946:2019” стандартыг мөрдүүлэх,Тогооч болон зөөгч барменыг чадавхжуулж зөв дадал хэвшлийг бий болгох үүднээс “**Чадамжийн хөтөлбөр II**” төслийг боловсруулсан.

Ийнхүү “Чадамжийн хөтөлбөр II” сургалт, дадлагын ажлыг 2024 оны 10 сарын 14-өөс элүүлэн 2 сарын хугацаанд 7 байгууллагын 50 тогооч, туслах ажилчдыг хамруулан хийсэн байна.



Сайнцагаан сумын Арвин их сан ХХК жимс, жимсгэнийн тариалалтын зориулалтаар 210.0 сая төгрөгийн хөнгөлөлтэй зээлд хамрагдсан Энэ онд шинээр 3 га талбайд алимны төгөл байгуулах зорилгоор, 4 төрлийн соортын алимны суулгац тариалж, ургалтын 90 хувьтай байна.




Сайнцагаан сумын иргэн С.Амарбаясгалан Бүгд найрамдах солонгос улсын технологиор барьсан $280 \times 4 = 1120$ м.кв хүлэмжид эрт ургацын байцаа, өргөст хэмхийг тариалж, нийт 16,5 тн-ийг ургац хураан авч орон нутгийн зах зээлд нийлүүлсэн.



Улаанбаатар хотоос шилжин ирсэн Дэлгэрэх плас инженеринг ХХК нь ЖДҮХСангаас ахуй үйлчилгээний чиглэлээр 990м² үйлчилгээний төвийг барьж ашиглалтанд оруулаад байна.

Ахуйн үйлчилгээний байрыг барихад нийт 1,8 тэрбум төгрөгийн санхүүжилт хийгдсэнээс өөрийн хөрөнгөөр 1,5 тэрбум төгрөгийг, ЖДҮХСангаас 300,0 сая төгрөгийн хөнгөлөлттэй зээлд хамрагдсан байна. Шинээр 10 ажлын байр бий болсон.



“Говийн өнгө - 2024” үзэсгэлэн худалдааг 9 сарын 13-15-ны өдрүүдэд Дундговь аймгийн Мандалговь хотноо зохион байгууллаа. Үзэсгэлэн худалдаанд Дундговь аймгийн 15 сум болон Өмнөговь, Дархан-Уул, Сэлэнгэ, Архангай аймаг, Улаанбаатар хотын нийт 200 гаруй үйлдвэрлэл эрхлэгч оролцож, гурван өдрийн турш 374,8 сая төгрөгийн борлуулалт хийжээ.



ДӨРӨВ. ДҮГНЭЛТ

Засгийн газрын зарим чиг үүргийг орон нутагт төлөөлөн хэрэгжүүлэх арга хэмжээний хүнс, хөдөө аж ахуйн хүрээнд хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний жилийн эцсийн хэрэгжилтэд хяналт шинжилгээ, үнэлгээ хийж 91,5 хувь буюу “Тодорхой үр дүнд хүрсэн” гэж үнэлж үнэлгээний саналыг хүргүүлж байна.

Хүнсний гол нэрийн төрлийн бүтээгдэхүүний хангамжийг нэмэгдүүлэх чиглэлээр Орон нутгийн үйлдвэрлэлээр гурилан бүтээгдэхүүн- 216.3 тонныг үйлдвэрлэж – 9 хувийг, Сүү, сүүн бүтээгдэхүүн –3,1 мян.л-ийг үйлдвэрлэж -0.09 хувийг, өндөг -77 тонныг үйлдвэрлэж 28 хувийг, мал төхөөрөх цэгт 237.5 тн мах

бэлтгэж 14.1 хувийг тус тус хангаж, нийт 51.19 хувийг хангасан байна. Өмнөх оноос 11,9 хувиар өссөн үзүүлэлттэй байна

Засаг даргын 2023 оны А/322 дугаар захирамжаар батлагдсан дэд хороо шалгарсан 12 төслийг хэлэлцэж, эрэмбэлсэн. Нарийвчилсан шатанд 12 төсөл тэнцсэнээс 1 дүгээр ээлжид 8 төсөлд 1,000,0 сая төгрөг, 2 дугаар ээлжид 4 төсөлд 570,0 сая төгрөгийг хуваарилсан. Энэ онд ХХААХҮЯамны сайдын тушаалаар 2-р ээлжийг санхүүжүүлэхээр болсон.

2024 онд А/28 тоот тушаалаар ЖДҮХСангаас 12 ААНэгжид 1,570,000,000 төгрөг олгосон байна

Энэ онд шинээр 44 ажлын байр бий болж, 30 ажлын байр хадгалагдсан байна.

Гэрээгээр хүлээсэн үүргээс дараах 2 заалтууд хэрэгжээгүй байна.

Мах, махан бүтээгдэхүүний үйлдвэрлэл, худалдааны техникийн зохицуулалтын хэрэгжилтийг хангаж, үйлдвэрийн аргаар бэлтгэсэн махны хэмжээг нэмэгдүүлсэн байх гэсэн заалт нь 2024 оны орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөд 500 сая төгрөг төсөвлөсөн боловч махны үйлдвэр байгуулах шаардлага хангасан аж ахуй нэгж ирээгүйн улмаас энэхүү заалтын хэрэгжилт хангалтгүй байна.

Аймгийн хүн амын хүнсний хангамж, аюулгүй байдлыг сайжруулах заалт нь итгэмжлэгдсэн Сорилтын лабораторид 2024 онд 1534 сорьцод 5392 үзүүлэлтээр шинжилгээ хийгдсэнээс 86 сорьц стандартын шаардлага хангахгүй эерэг гарсан нь нийт сорьцын 5,6%-ийг эзэлж байна. Стандартын шаардлага хангаагүй сорьцын эзлэх хувь өмнөх оноос өссөн нь 2 удаагийн хоолны хордлогын хүнс, ус, эрүүл зүйн шинжилгээний сорьц шинжлэгдсэнтэй холбоотой байна.

ТАВ. ЗӨВЛӨМЖ

Хөгжлийн бодлого, төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтэст:

Гэрээнд тусгагдсан үүргийн хэрэгжүүлэх арга хэмжээг төлөвлөхдөө шалгуур үзүүлэлт, суурь түвшин, хүрэх түвшнийг бодитой судалгаанд үндэслэн тодорхойлох

Гэрээгээр хүлээсэн үүргийн хэрэгжилтийн талаар аймгийн удирдлагуудыг тогтмол хугацаанд мэдээллээр хангаж, хэрэгжилт удааширсан болон тасарч болзошгүй заалтыг эрчимжүүлэх арга хэмжээг тухай бүр авч ажиллаж байх


Хүнс, хөдөө аж ахуйн газарт:

Тайланг товч, тодорхой утга санааг бүрэн гүйцэт илэрхийлсэн, итгэл үнэмшил төрөхүйц, тоон мэдээлэл болон нотлох баримтын хамт гаргаж ирүүлэх.

Зарцуулсан хөрөнгийн хэмжээг бичиж ирүүлэх.

Сайдтай байгуулсан гэрээний хүрээнд хариуцан хэрэгжүүлэх арга хэмжээнд ач холбогдол өгч хэрэгжүүлэн тайланг нотлох баримттайгаар тайлагнаж байх

БАТАЛГААЖУУЛСАН
АЙМГИЙН ЗАСАГ ДАРГА  С.МӨНХЧУЛУУН
ХЯНАСАН:
ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ХЭЛТСИЙН
ДАРГА  Д.ДААРИЙМАА
ТАЙЛАН БИЧСЭН:

ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ
ХЭЛТСИЙН МЭРГЭЖИЛТЭН  Б.СОЛОНГО